



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/524

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Төрийн аудитын газраас 2020 оны 9-10 дугаар сард сумдад орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын үр дүнд аудит хийх арга хэмжээний шатахууны зардалд 1600.0 мянган төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулах 1600.0 мянган төгрөг/ Нэг сая зургаан зуун мянган төгрөг/-ийг аймгийн хөрөнгө оруулалтын захиалагчийн техник хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр  
сарын 18-ны өдрийн А/524 дүгээр  
захирамжийн хавсралт

СУМДАД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНД АУДИТ ХИЙХ ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

дд	Явах чиглэл	Явах км	Хэмжих нэгж	Шатахууны хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/
1.	Алтай, Үенч, Булган	1330	летр	265.9	2100.00	558.4
2.	Манхан, Мөнххайрхан, Мөст, Цэцэг,	1020		204		428.4
3.	Зэрэг, Дарви, Чандмань, Дөргөн,	980		196		411.6
4.	Дуут, Ховд, Эрдэнэбүрэн, Буянт, Мянгад	480		96		201.6
	Дүн	3810		761.9		1600.0

-оОо-